



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

ШУТИС-ийн 2022 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3 дугаар заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтууд, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2022 оны үйл ажиллагааны орлогын төсвийг 64,879,468.900.0 (жаран дөрвөн тэрбум найман зуун далан есөн сая дөрвөн зуун жаран найман мянга есөн зуун) төгрөгөөр тогтоож нэгдүгээр хавсралтаар, зарлагын төсвийг 64,643,366.900.0 (жаран дөрвөн тэрбум зургаан зуун дөчин гурван сая гурван зуун жаран зургаан мянга есөн зуун) төгрөгөөр тогтоож хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг 4,257,300.000.0 (дөрвөн тэрбум хоёр зуун тавин долоон сая гурван зуун мянга) төгрөгөөр тогтоож гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, батлагдсан төсвийн дагуу захиран зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг ШУТИС-ийн захирал (Б.Очирбат)-д даалгасугай.

ДАРГА



Г.ГАНБАЯР

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын
13.. -ны өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ШУТИС-ИЙН 2022 ОНЫ ОРЛОГЫН ТӨСӨВ
/мян төг/

Үзүүлэлт	ДҮН
Шилжих үлдэгдэл	9,305,160.0
I. Сургалтын төлбөрийн орлогын дүн	43,301,720.0
II. Түр сургалтын орлогын дүн	2,899,450.0
1 Жолооны курс	-
2 Лицейн сургалт	1,649,250.0
Суралцагчдын тоо	1,248.0
Сургалтын төлбөр (жилд)	8,589.3
3 Курс дамжаа, сургалт явуулах	1,250,200.0
III. Оюутны байрны орлогын дүн	860,750.0
1 Байранд сууж байгаа оюут. тоо	1,310.0
2 Жилийн дундаж төлбөр (мян.төг)	1,400.0
3 Оюутнаас орох орлогын дүн	718,150.0
4 Байранд сууж б.гаа багш.а. тоо	60.0
5 Сарын дундаж төлбөр (мян төг)	200.0
6 Суух хугацаа (сараар)	-
7 Эдгээрээс орох орлого	142,600.0
IV. Эрдэм шинжилгээний орлогын дүн	3,638,500.0
1 Төвүүдийн орлого	254,500.0
2 Гэрээт ажил	1,581,000.0
3 Төсөл	1,803,000.0
V. Түрээсийн орлогын дүн (40%хасаад)	155,455.2
1 Түрээслүүлж буй объектын тоо	14.0
2 Түрээслүүлж буй талбай (м.кв)	907.1
3 Түрээслэх хугацаа (сараар)	66.0
4 Сарын төлбөр (мян.төг)	12,076.7
5 Үүнээс гадна авах төлбөр	31,423.2
VI. Бусад орлогын дүн	3,491,250.0
1 Хандив тусламжийн орлого	420,000.0
2 Үйлдвэрлэлийн орлого	2,327,600.0
3 Бусад орлого	743,650.0
4 Хүүгийн орлого	-
VII. Төсвөөс санхүүжих дүн	1,227,183.7
1 Оюутны унааны зардал	102,500.0
2 Оюутны тэтгэлэг	-
3 Тогтмол зардал	-
4 Лицейн төлбөр	138,408.8
5 МСҮТ хувьсах зардал	482,332.9
6 Хоолны зардал	56,810.0
7 ЭША-ны ажилтны санхүүжилт	351,745.9
8 Тэтгэмж	-
9 Хөрөнгө оруулалт	-
10 Урсгал санхүүжилт	95,386.1
БҮГД ОРЛОГЫН ДҮН	64,879,468.9